


UCS1502C:2023

БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК




Цахилгаан шатанд тавигдах
ерөнхий шаардлага

БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК

Цахилгаан шатанд тавигдах
ерөнхий шаардлага

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 41-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	4
4. Цахилгаан шатыг төлөвлөх	5
5. Цахилгаан шатыг угсрах, засвар, техникийн үйлчилгээ	11

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Цахилгаан шатны I ,II ба IV ангилал”-ын машины бүхээгийн хэмжээсүүд (Жишээ зураг)	7
Зураг 2. Ангилал I” - орон сууцны цахилгаан шатны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал /Жишээ зураг/	8
Зураг 3. “Ангилал I” - орон сууцны цахилгаан шатны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал /Жишээ зураг/	8
Зураг 4. “Ангилал III, VI өндөр даацын лифт”-ны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал (Жишээ зураг)	8
Зураг 5. “Ангилал III, VI өндөр даацын лифт”-ны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал	8
Зураг 6. Хүртээмжтэй цахилгаан шатны стандарт хэмжээ (Жишээ зураг).....	10
Зураг 7. Хүртээмжтэй цахилгаан шатны товчлуурын байршил болон байршлын хэмжээсүүд (Жишээ зураг).....	10
Зураг 8. Цахилгаан шатны үндсэн эд анги болон бүрдэл хэсгүүд (Жишээ зураг).....	12
Зураг 9. Тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах жишээ.....	14

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цахилгаан шатны зориулалт, давхар, даац, давхрын тоогоор ангилсан байдал.....	6
Хүснэгт 2. Цахилгаан шатны ангилал	6
Хүснэгт 3. Цахилгаан шатны бүхээгийн шалны ашигтай талбайг даацаас хамааруулсан хүснэгт	7
Хүснэгт 4. Цахилгаан шатанд хориглох үйлдлүүд.....	13



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

┌ Барилгын хийц, эдлэхүүн, техникт ┐
хамаарах хотын стандартыг батлах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг; Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн “Барилгын материал” бүлэгт хамаарах дор дурдсан хотын стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1504C:2023 “Хаалга, цонхонд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1502C:2023 “Цахилгаан шатанд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартыг олон нийтэд сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Б.Мягмар)-нд даалгасугай.


ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100565

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 11 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



БАРИЛГЫН ХИЙЦ, ЭДЛЭХҮҮН, ТЕХНИК

UCS 1502C:2023

“ЦАХИЛГААН ШАТАНД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” - ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү хотын стандартыг барилгын цахилгаан шатыг угсрах, аюулгүй байдлыг хангуулах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Барилгын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм (Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2008 оны 53 тоот тушаалын нэгдүгээр хавсралт);
- Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03;
- MNS ISO 4101 : 2003, “Элеваторын татлагын ган утасны техникийн нөхцөл”;
- MNS ISO 4190-1 : 2011, “Лифт угсралт – 1 дүгээр хэсэг: Ангилал I, II, III ба VI” ;
- MNS ISO 4190-2 : 2011, “Лифт угсралт – 1 дүгээр хэсэг: Ангилал I, II, III ба VI” ;
- MNS ISO 4190-2 : 2003, “Зорчигчийн лифт ба үйлчилгээний лифт. 2-р хэсэг: IV ангийн лифт”;
- MNS ISO 4190-3 : 2003, “Зорчигчийн лифтийн угсралт. 3-р хэсэг: V ангийн үйлчилгээний лифт”;
- MNS ISO 4190-5 : 2003, “Лифт ба үйлчилгээний лифт. (АНУ: элеватор ба буфет автомат) 5-р хэсэг: Удирдлагын хэрэгсэл, дохио, нэмэлт төхөөрөг”;
- MNS ISO 4190-6 : 2010, “Лифт ба үйлчилгээний лифт (АНУ: лифт ба бага даацын үйлчилгээний лифт) – Хэсэг 6: Зорчигчийн лифтийг орон сууцанд угсран суурилуулах. Төлөвлөлт, сонголт”;
- MNS ISO 4344 : 2003, “Лифтийн ган утсан татлага”;
- MNS ISO 7465 : 2010, “Зорчигчийн ба үйлчилгээний лифт – Лифтний бүхээг болон эсрэг ачааг чиглүүлэх зам – “Т” төрөл”.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Машины өрөө- гэж лифтний тоног төхөөрөмжийг гадны нөлөөнөөс хамгаалах зориулалт бүхий тусгай өрөө;

Чиглүүлэгч зам-гэж чиглүүлэгч – бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн хоёр хажууд байрлаж, тэдгээрийн шилжих хөдөлгөөнийг чиглүүлж өгөх зам;

Хурд хязгаарлагч- гэж бүхээг /эсрэг ачаа, тэнцүүлэгч/-ийн хурд хэтэрсэн тохиолдолд тэдгээрийн баригчийн төхөөрөмжийг ажиллуулах зорилготой төхөөрөмж;

Баригч – гэж хурд хязгаарлагчийн удирдлагаар цахилгаан шатны бүхээгийг чиглүүлэгч зам төмөрт барьж зогсоох ослоос хамгаалах тоноглол;

Дамар – гэж бүхээг, эсрэг ачаа /тэнцүүлэгч/-г өргөж буулгах татлагад хөдөлгөөн дамжуулдаг эд анги;

Дуудлагын товчлуур - гэж бүхээгийг зогсоолын түвшинд авчрах, давхарт байрлах товчлуур;

Огцом тоормослох баригч - гэж бүтэцдээ зөөлөн, уян хатан эд ангийг агуулаагүй баригч.

4. ЦАХИЛГААН ШАТЫГ ТӨЛӨВЛӨХ

4.1. Ерөнхий шаардлага

- 4.1.1. Цахилгаан шатыг угсрах, аюулгүй байдлыг хангуулах, засвар үйлчилгээ хийх үйл ажиллагаанд “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ажиллагааны дүрэм”-д заасан шаардлагуудыг хангаж ажиллана.
- 4.1.2. Лифт эзэмшигч нь түүний ажиллагаанд хяналт тавьж, засвар, үйлчилгээг тогтмол хийх зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар лифтний бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангаж, засвар техник үйлчилгээ болон магадлалыг цаг хугацаанд нь тогтмол хийлгэх, мэргэжлийн лифтчинг ажиллуулах мөн осол аваар гарч болзошгүй үед лифтний ашиглалтыг зогсоох, Улсын байцаагчийн болон Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн бүрэн эрхийн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлнэ.
- 4.1.3. Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага нь стандартын шаардлага хангасан лифт угсарч, суурилуулах, засвар, үйлчилгээг хийхдээ лифтний эд ангийн зай хэмжээг тохируулах, чанар, эдэлгээ, аюулгүй ажиллагааг тогтмол шалгаж байна.
- 4.1.4. Барилга байгууламжийн цахилгаан шатыг “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-д заасны дагуу техникийн болон аюулгүй ажиллагааны шалгуурыг бүрэн хангуулснаар ашиглана.
- 4.1.5. БНБД 31-01-10 “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” болон Хүснэгт 1-д заасны дагуу цахилгаан шатыг төлөвлөн гүйцэтгэнэ.

4.2. Цахилгаан шатыг суурилуулах барилгад тавигдах ерөнхий шаардлага

- 4.2.1. Лифтний тоног төхөөрөмжийг байрлуулах зориулалттай барилгын хэсэг нь лифт ашиглалтын ба туршилтын үед, түүнчлэн ган татлага буюу гинж тасрах үед үүсэх ачааллыг даахаар тооцоологдсон байна.
- 4.2.2. Лифтний тоног төхөөрөмжийг байрлуулах барилгын хэсэг нь холбогдох барилгын норм ба дүрэм болон “Цахилгаан байгууламжийн дүрэм” /БД 43-101-03–ийн 5 дугаар бүлгийн заалт шаардлагад нийцүүлэн галын аюулгүй байдлыг хангасан байна.
- 4.2.3. Лифтний тоног төхөөрөмжийг байрлуулах байрны барилгын зураг төсөлд түүний ашиглалтын үед тавигдах шаардлагын дагуу халаалт, салхивчийн төхөөрөмжийг байрлуулах нөхцөлийг тусгасан байна.

Хүснэгт 1. Цахилгаан шатны зориулалт, давхар, даац, давхрын тоогоор ангилсан байдал

Орон сууцны барилга	Давхар	Цахилгаан шатны тоо	Даац кг, хурд м/с	Давхрын айлын сууцны хамгийн их талбай, ам/м
Нийтийн зориулалттай орон сууцны барилга	10 хүртэл	1	400; 1.0	600
	11-12	2	400; 1.0	600
	13-17	2	630; 1.0	450
	18-19	3	400; 1.6	450
	20-25	3	400; 1.6 400; 1.6 630; 1.6	300
Өндөр настны	3-5	1	630; 1.0	800
	6-9	2	400; 1.0	600
Хөгжлийн бэрхшээлтэй хүнд	2-3	1	630; 1.0	800
	4-5	2	630; 1.0	800

4.3. Цахилгаан шатны ангилал

Цахилгаан шатыг зориулалт, хүчин чадлаар нь хэрхэн ангилахыг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Цахилгаан шатны ангилал

№	Ангилалтын нэр	Зориулалт	Онцлог
1	АНГИЛАЛ I	Зөвхөн хүн тээвэрлэх	Хүн тээвэрлэхэд зохиулагдсан лифт
2	АНГИЛАЛ II	Гол төлөв хүн болон зөвшөөрөгдсөн ачаа тээвэрлэх	Гол төлөв хүн тээвэрлэдэг, гэхдээ зөвшөөрөгдсөн ачаа тээвэрлэхэд зориулагдсан лифт. Орон сууцны барилгад 1000 кг ачааны даацтай лифтний хэмжээг төлөвлөхийг тусгайлан зөвлөдөг ба эсхүл III ангиллын лифт зохимжтой гэж үздэг.
3	АНГИЛАЛ III	Эмнэлэг болон асаргаа, сувиллын барилга	Бүхээгийн зөвшөөрөгдөх ачаа 2500, 2000, 1600, кг лифт хүн ба эмнэлгийн зориулалттай (1000 мм х 2300 мм), (900 мм х 2300 мм) хэмжээст ор, эмнэлгийн нэмэлт тоног төхөөрөмж болон дагалдах хүнийг тээвэрлэхэд тохиромжтой.
4	АНГИЛАЛ IV	Ачаа тээвэрлэх	Ихэвчлэн ачаа тээвэрлэдэг, шаардлагатай үед ачаа дагалдах хүн хамт тээвэрлэх зориулалттай лифт, 2,5 м/с –с дээш хурдтай, өндөр даацын лифтийг 15 –аас дээш давхартай өндөр барилгад хэрэглэхэд тохиромжтой.
5	АНГИЛАЛ V	Үйлчилгээний	Үйлчилгээний лифт/GB/ Гал тогооны лифт/US/
6	АНГИЛАЛ VI	Үйлчилгээний иж бүрэн барилга	Гол төлөв үйлчилгээний иж бүрэн барилгад суурилуулдаг, 2,5 м/с ба түүнээс дээш хурдтай даацын лифт

Эх сурвалж: MNS ISO 4190-1 : 2011 стандарт


4.4. Бүхээгийн даац, багтаамж

- 4.4.1. Лифтний даац нь 2500 кг–аас дээш бол нэмэгдсэн 100кг бүрд бүхээгийн ашигтай талбайг 0.16 м²-аар нэмэгдүүлнэ. Даацын завсрын хэмжээст түүнд ноогдох талбайг даацаас хамааруулсан шугаман харьцаагаар тодорхойлно.
- 4.4.2. Лифтний бүхээгийн багтаамж, даацыг тогтооход нэг хүний жин 75кг байхаар бодож тооцно.
- 4.4.3. Лифтний хийц хэсгийн тооцоог хийхдээ үйлдвэрийн дотоод зөөврийн /авто


ачигч, цахилгаан кар г.м/ хэрэгслийг ачаатай нь зөөвөрлөдөг зориулалттай лифтний бүхээгт энэ төрлийн тээврийн хэрэгсэл орох /гарах/ үед үүсэх динамик ачааллыг оролцуулан тооцно.

Хүснэгт 3. Цахилгаан шатны бүхээгийн шалны ашигтай талбайг даацаас хамааруулсан хүснэгт


Лифт-ийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, м-аас илүүгүй	Лифт-ийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, м-аас илүүгүй	Лифт-ийн даац, кг	Бүхээгийн шалны ашигтай талбай, м-аас илүүгүй
100	0.37	675	1.75	1200	2.80
180	0.58	750	1.9	1250	2.90
225	0.7	800	2.00	1275	2.95
300	0.9	825	2.05	1350	3.1
375	1.10	900	2.20	1425	3.25
400	1.17	975	2.35	1500	3.40
450	1.3	1000	2.40	1600	3.56
525	1.45	1050	2.50	2000	4.20
600	1.6	1125	2.65	2500	5.0
630	1.66				




Зураг 1. “Цахилгаан шатны I ,II ба IV ангилал”-ын машины бүхээгийн хэмжээсүүд (Жишээ зураг)




Зураг 2. “Ангилал I” - орон сууцны цахилгаан шатны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал /Жишээ зураг/



Зураг 3. “Ангилал I” - орон сууцны цахилгаан шатны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал /Жишээ зураг/



Зураг 4. “Ангилал III, VI өндөр даацын лифт”-ны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал (Жишээ зураг)



Зураг 5. “Ангилал III, VI өндөр даацын лифт”-ны ашигтай талбайг зургаар илэрхийлсэн байдал

4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахилгаан шатны хэмжээ

- 4.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан цахилгаан шат нь тэдгээр хүмүүс орох боломжтой гарцтай холбон угсрах бөгөөд барилгын гадна хаалгатай аль болох ойр байрлалд угсарна.
- 4.5.2. Цахилгаан шатны өмнөх суух талбай нь 1,4м х1,4м буюу 1,96м.кв-с дээш байх ёстой.
- 4.5.3. Суух талбайн босго, цахилгаан шатны бүхээгийн хоорондын зай нь 3см хүртэл байна.

4.6. Зорчигчийн жолоодлогын тоноглол


- 4.6.1. Гадна дуудлагын товчлуур, дуудлагын самбар ослын дуудагч зэрэг цахилгаан шатны дотор ба гадна байрлах бүх товчлуурууд шалнаас дээш 0,8 метрээс дээш, 1,2метр хүртэл өндөрт байрлана. Гэвч товчлуурын тоо хэт олноос 1,2 метрт багтаах боломжгүй тохиолдолд 1,4 метр хүртэл өндөрт байрлуулж болно.
- 4.6.2. Цахилгаан шатны дотор тэргэнцэртэй хүмүүст зориулсан дуудлагын самбарыг бүхээгийн гаднаас харахад баруун гар талд, шалнаас 0,85 метрээс өндөрт, хөндлөнгөөр байрлуулна. Харин цахилгаан шатны шалны талбай 1,4м х 1,4м-с их тохиолдолд өмнөхийн эсрэг буюу зүүн гар талд байрлуулж болно.
- 4.6.3. Эдгээр жолоодлогын тоноглолыг товчлуур хэлбэрээр хийх ба харааны согогтой хүмүүст зориулан тоо болон бусад тэмдэгтийг баррель үсгээр илэрхийлнэ.
- 4.6.4. Дуудлагын самбар, ослын дуудлагын товчлуурт баррель үсгээр бичсэн санамжийг заавал байрлуулна.

4.7 Бусад тоноглол

- 4.7.1. Цахилгаан шатны доторх хөндлөн бариул нь шалнаас 0.8 метрээс дээш 0.9 метр хүртэл өндөрт үргэлжилсэн уртаар, эсхүл бариул хооронд 3

сантиметрийн зайтайгаар хажуу болон хойд талд тус тус угсарч, бариулыг бусад үзүүлэлтэд барилгын бариулын стандартыг мөрдөнө.

- 4.7.2. Цахилгаан шатны бүхээгт тэргэнцэртэй хүн бүрэн эргэх хангалттай талбайгүй тохиолдолд тэргэнцэр ухарч ороход зориулан хойд талын хананд / 0.6 метрээс дээш/ байдлыг хянаж болохуйц гэрэл, толийг байрлуулна.
- 4.7.3. Давхар бүрийн суух талбайд цахилгаан шатны байрлалыг илтгэгч, дуу хоолойгоор илэрхийлэгчийг угсран, цахилгаан шатны бүхээгт мөн адил дуу хоолойгоор болон гэрлээр давхар илтгэгчийг угсарч өгнө.
- 4.7.4. Хүн ба ямар нэгэн эд зүйл цахилгаан шатны хаалганд хавчуулсан тохиолдолд хаалга автоматаар зогсон, дахин онгойх хаалга дахин онгойх үйлдлийг заавал идэвхжүүлнэ.
- 4.7.5. Цахилгаан шатны доторх байдлыг гадна талаас харах боломжтойгоор нүүрэн талын тодорхой хэсгийг шилээр хийж болно.
- 4.7.6. Давхраас хамааран буух хаалга өөр байх тохиолдолд цахилгаан шат давхарт хүрэхэд, буух чиглэлийг дуу хоолойгоор заавал танилцуулж байна.
- 4.7.7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн аюулгүй байдлын тулд бүхээг, суух талбай зэргийн гэрлийг 150lx-с дээш чадалтай ламп хийх шаардлагатай.



Зураг 6. Хүртээмжтэй цахилгаан шатны стандарт хэмжээ (Жишээ зураг)



Зураг 7. Хүртээмжтэй цахилгаан шатны товчлуурын байршил болон байршлын хэмжээсүүд (Жишээ зураг)

5. ЦАХИЛГААН ШАТЫГ УГСРАХ, ЗАСВАР, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Цахилгаан шатны засвар, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага;

- Цахилгаан шатны засвар үйлчилгээг Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага гүйцэтгэнэ;
- Монгол улсын MNS ISO 4190–1:2011, олон улсын стандартад нийцсэн тохирлын гэрчилгээтэй лифтийг угсарч суурилуулна.
- Засвар, техник үйлчилгээг үзүүлэхдээ “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг баримтлан ажиллана.
- Засвар, техник үйлчилгээг цаг хугацаанд нь технологийн зааврын дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.
- Техникийн паспорт, бичиг баримтын бүрдлийг “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу хангаж ажилласан байна.
- Өргөх байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага техникийн магадлал ба үзлэг, шалгалтаар лифтний эвдрэл гэмтлийг цаг алдахгүй оношлох, засварлах, мөн арилгаж болохгүй, лифтний ашиглалтын аюулгүй ажиллагаанд нөлөөлөх гэмтлүүд илэрсэн тохиолдолд лифт эзэмшигчид мэдэгдэж лифтийг нэн даруй зогсооно

5.2. Цахилгаан шатны төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засвар техникийн үйлчилгээнээс бүрдсэн техникийн үйлчилгээний систем нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

- үечилсэн үзлэг, урсгал засвар, агаар-техникийн үйлчилгээнээс бүрдсэн техникийн үйлчилгээний систем;
- их засвар, ашиглалтын явцад өөрчлөн сайжруулах ажлаас бүрдсэн цахилгаан шатыг сэргээн засварлах үйл ажиллагаа.

5.3. Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварын ажлыг гүйцэтгэхэд мэргэжлийн байгууллагыг оролцуулж болно.

5.4. Цахилгаан шат ашиглагч болон мэргэжлийн байгууллага нь ажлын багтаамж нөхцөлөөс хамааран ажиллах хүчний баг бүрдүүлсэн байна.

5.5. Цахилгаан шатны үечилсэн үзлэгийг лифтчин гүйцэтгэнэ.


5.6. Диспетчерийн хяналттай лифтний үйлчилгээг мэргэжлийн хяналтын байгууллагатай зохицон өөр үечлэлээр гүйцэтгэж болно.

5.7. Засвар, техникийн үйлчилгээ гүйцэтгэх эрх бүхий байгууллага нь дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- цахилгаан шат эзэмшигчид цахилгаан шатны паспортыг хэрхэн хөтлөх бусад холбогдох бичиг баримтыг яаж бүрдүүлэх талаар мэргэжлийн зүгээс заавар, зөвлөгөө өгөх;
- цахилгаан шат ашиглалтын талаар гарч буй аюулгүй ажиллагааны зөрчил, дутагдлыг арилгах талаар лифт эзэмшигчид зөвлөгөө өгч, биелэгдэхгүй байгаа зөрчлийн талаар хяналтын байгууллагад мэдэгдэх;
- давхар бүрд лифт ашиглах заавар, машин зааланд лифтний цахилгааны схем, тосолгооны картыг хийж тавихыг шаардаж, хийхэд нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- цахилгаан шатанд засвар, техникийн үйлчилгээ хийх график төлөвлөгөө боловсруулж, байгууллагын даргаар батлуулан мөрдөж ажиллах;
- цахилгаан шатанд засвар хийсэн тохиолдолд гүйцэтгэсэн ажлаа лифтний ашиглалтыг хариуцагчид хүлээлгэн өгөөд, паспорт дээр өөрийн хийсэн ажлаа дэлгэрэнгүй бичиж гарын үсгээ зурна. Шаардлагатай үед цахилгаан шатанд

хэсэгчилсэн техникийн магадлал хийж акт үйлдэнэ;

- техникийн үйлчилгээг хийхдээ лифтийн ашиглалтын зааварт бичигдсэн технологийн дагуу эзэмшигч байгууллагын төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэж, тэдэнд хийж байгаа ажлаа тайлбарлан, хэрхэн хяналт тавьж байх талаар зааж зөвлөнө;
- мэргэжлийн хяналтын байгууллагаас лифт эзэмшигч байгууллагад өгсөн албан шаардлагаас гэрээний үүргийн дагуу өөрт хамаарагдах хэсгийг дурдсан хугацаанд нь биелүүлэх.



Зураг 8. Цахилгаан шатны үндсэн эд анги болон бүрдэл хэсгүүд (Жишээ зураг)

5.8. Лифтэнд сар бүр үзлэг шалгалт хийж техникийн бүрэн бүтэн байдлыг шалган 12 сард 1-ээс доошгүй техникийн магадлалыг хийнэ.









5.9. Лифтний дараах эд ангийг сольсны дараа хэсэгчилсэн техникийн магадлал хийнэ. Үүнд:

- бүхээг;
- эргүүлэг/өргүүр/;
- ган татлага, хөтлөх хүрд;
- ослоос хамгаалах баригчууд;
- хурд хязгаарлагч;
- удирдлагын шкафыг сольсны дараа буюу цахилгаан схемд өөрчлөлт оруулсан үед.

5.10. Цахилгаан шатанд хориглох үйлдлүүдийг мэдээлэх тэмдгийг (Хүснэгт 4) цахилгаан шатны бүхээг дотор заавал байрлуулна.

5.11. Цахилгаан шатанд засвар, үйлчилгээ хийх, гэмтэл гарсан тохиолдолд лифт эзэмшигч нь анхааруулах тэмдэг, тэмдэглээг лифтний хаалганы урд, нүдэнд харагдахуйц ил газар заавал байрлуулж, хаалгыг битүүмжилнэ (Зураг 9).

Хүснэгт 4. Цахилгаан шатанд хориглох үйлдлүүд

	Хаалга хүчээр нээхийг хориглоно эвдрэх аюултай		Өшиглөхийг хориглоно
	Хаалга налахыг хориглоно		Хаалга бүрэн нээгдсэний дараа гарна уу
	Хаалгыг хүчээр барихыг хориглоно		Тэсрэх дэлбэрэх зүйл тээвэрлэхийг хориглоно
	Зорчигч буусны дараа сууна уу		Даац хэтрүүлэхийг хориглоно

	<p>Бага насны хүүхдийг хөтөлж орно уу</p>		<p>Гэмтэл гарсан үед дуут дохио өгөх</p>
	<p>Үсрэхийг хориглоно</p>		<p>Гэнэтийн ослын үед цахилгаан шатыг ашиглахыг хориглоно</p>



Анхааруулах тэмдэг



Хамгаалалтын хаалт

Зураг 9. Тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах жишээ

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- БНБД 31-03-03 Олон нийтийн иргэний барилга;
- Барилгын тухай хууль 2016;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- MNS ISO 4101 : 2003, “Элеваторын татлагын ган утасны техникийн нөхцөл”;
- MNS ISO 4190-1 : 2011, “Лифт угсралт – 1 дүгээр хэсэг: Ангилал I, II, III ба VI”;
- MNS ISO 4190-2 : 2003, “Зорчигчийн лифт ба үйлчилгээний лифт. 2-р хэсэг: IV ангийн лифт”;
- MNS ISO 4190-3 : 2003, “Зорчигчийн лифтийн угсралт. 3-р хэсэг: V ангийн үйлчилгээний лифт”;
- MNS ISO 4190-5 : 2003, “Лифт ба үйлчилгээний лифт. (АНУ: элеватор ба буфет автомат) 5-р хэсэг: Удирдлагын хэрэгсэл, дохио, нэмэлт төхөөрөг”;
- MNS ISO 4190-6 : 2010, “Лифт ба үйлчилгээний лифт (АНУ: лифт ба бага даацын үйлчилгээний лифт) – Хэсэг 6: Зорчигчийн лифтийг орон сууцанд угсран суурилуулах. Төлөвлөлт, сонголт”;
- MNS ISO 4344 : 2003, “Лифтийн ган утсан татлага”;
- MNS ISO 7465 : 2010, “Зорчигчийн ба үйлчилгээний лифт – Лифтний бүхээг болон эсрэг ачааг чиглүүлэх зам – “Т” төрөл”.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар